



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.01 № 01/645-

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИГЧ БҮДЭЭГИЙН БАТБАЯР  
ТАНАА**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Бүдээгийн Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Бүдээгийн Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Бүдээгийн Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Бүдээгийн Батбаярт

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЦЭЦҮХ БАГ 2 ДУГААР ТОЙРОГТ БИЕ  
 ДААН НЭР ДЭВШИГЧ БҮДЭЭГИЙН БАТБАЯРЫН 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

№	Хийгдэх үйл ажиллагаа	ий	Хийгдэх хугацаа	Санхүүгийн эх үүсвэр
1	Зуны цэцэрлэгийг баг бүрт тохиромтой цаг хугацаанд нь гаргаж суруулийн өмнөх боловсрол олгох ажлыг хөдөө багруу ойртуулж хамран сургалтыг нэмэгдүүлэх бодлого баримтлана.		2024-2028 он	Улсын төсвөөр
2	Дотуур байрны хүүхдийн хоол, үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтийг дэмжсэн эрүүл хүнсээр хангах тал дээр анхаарч, хяналтыг сайжруулна.		2024-2028 он	Улсын төсвөөр
3	“Оюунлаг Спортлог Жаргалантчууд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, амжилт гаргасан багш, сурагчдыг дэмжиж ажиллана.		2024-2028 он	Улсын төсвөөр
4	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог ерх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний хэлбэрийг бий болгох асуудлыг шийдвэрлүүлнэ.		2024-2028 он	Санхүүжилт шаардлагагүй
5	Эрүүл шүд хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийн шүдний өвчлөлийн асуудалд онцгой анхаарч ажиллана		2024-2028 он	Улсын төсвөөр
6	Хөдөлмөр эрхлэлтийг сайжруулж, ажилгүйдлийг бууруулах зорилгоор иргэн, хоршоо, аж ахуйн нэгжүүдийг төсөл хөтөлбөрт хамруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтлана.		2024-2028 он	Улсын төсвөөр
7	Иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран иргэдэд хууль тогтоомжийг сурталчилан ажиллана.		2024-2028 он	Санхүүжилт шаардлагагүй



1720090001  
 40000001

